**Б. Цагдаагийн алба хаагчдын дунд шатны тусгай бэлтгэлийн сургалт:**

Цагдаагийн алба хаагчийн дунд шатны тусгай бэлтгэлийн сургалт нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгэмийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг бүхий офицер бүрэлдэхүүнд заагдана.

**Дунд шатны тусгай бэлтгэлээр дараах сургалт бэлтгэл хнийгдэнэ.**

1. Бие бялдрын бэлтгэл
2. Бие хамгаалах тактик
3. Холбооны бэлтгэл
4. Амьд үлдэх арга
5. Галт зэвсгийн бэлтгэл
6. Усны бэлтгэл
7. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бэлтгэл зэрэг байна.

**3. Цагдаагийн алба хаагчийн гүнзгнйрүүлсэн тусгай бэлтгэлийн сургалт:**

Гүнзгийрүүлсэн тусгай бэлтгэлийн сургалт нь тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад заагдах бэлтгэл сургалтыг ойлгоно. Цагдаагийн алба хаагчийн гүнзгийрүүлсэн тусгай бэлтгэл нь анхан шатны, дунд шатны бэлтгэл сургуулилтанд тулгуурлан бие бүрэлдэхүүнийг биеийн хүч хэрэглэх ,галт зэвсэг эзэмших, тусгай хэрэгсэл, техникийг чадварлаг ашиглаж сургах, алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, бусад төрлийн ажилтнуудтай уялдаатай ажиллах бэлтгэлийг хангуулах, тусгай ажиллагааны тактикийн дадлага,чадварыг дээшлүүлэх. Энэ бэлтгэлийн үед янз бүрийн хэлбэрийн сургалтыг явуулна. Тэдгээрээс гол сургалтууд нь тусгай тактикийн бэлтгэл, хээрийн сургалт гэсэн сургалт бэлтгэлийг хамруулна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*цагдаагийн хошууч Б. Сүхбат*

## ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Өнөө үед хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдал, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд аюул учруулахуйц аюулт үзэгдэл, гамшгийн тоо харьцангуй нэмэгдэж, түүнээс учрах хор уршгийн үр дагавар улам бүр нэмэгдэж, үүссэн онцгой нөхцөл байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд ердийн арга хэрэгслээр хэвийн байдалд оруулах боломжгүй нөхцөл байдал бий болсоор байгаа ба энэхүү аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг удирдан зохион байгуулахыг Монгол Улс өөрийн эдийн засаг, нийгэм, үндэсний аюулгүй байдлын алс хэтийн бодлогодоо тусгах цаг аль хэдийн болсон байна.

Онцгой нөхцөл байдал гэж Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдал, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд аюул учруулхуйц байдал үүсч түүнийг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд ердийн арга хэрэгслээр хэвийн

байдалд оруулах боломжгүй болсон гэнэтийн оорчлөлтийн үр дүнд үүссэн аюултай нөхцөл, байдлыгойлгодог[1].

Уур амьсгал, газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үер, түймэр, хүн малын гоц халдварт өвчин, нийтийг хамарсан эмх замбраагүй байдал зэрэг нь дэлхий нийт болон Монгол Улсын аль ч улиралд тохиолдолж нийгэм эдийн засаг аж ахуй нэгж, ард иргэдийн өмчид ихээхэн хохирол учруулж, хэвийн ажилллагаанд нь сөрөг нөлөө үзүүлсээр байна. Тухайлбал, Гадны улс оронд:

- 2004 оны 2 сарын 5-нд Бээжин хотын Миюун дүүрэгт дэнлүүний баярын үеэр 37 хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан;
- 2004 оны 5 сарын 9-нд Чечений нийслэл Грозны хотын Динамо стадионд Германчуудыг ялсны ойн баяр тэмдэглэх үеэр дэлбэрэлт болж 10 хүн амь насаа алдсаны дотор Чечений ерөнхийлөгч Ахмад Кадиров, Оросын хойд Кавказын генерал Валери Баранов нар амь үрэгдсэн.
- 2005 оны 1 сарын 25-нд Энэтхэгийн Хинду шашинтнуудын баяр баруун Махараштa мужийн Мандхар Деви сүмд явагдах үед ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшид бусдыг хөлд гишгэгдэн 300 хүн амь насаа алдсан.
- 2005 оны 8 сарын 31-ны өдөр Багдад хотын хойт хэсгийн гүүрэн дээр 1000 орчим хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан;
- 2006 оны 1 сарын 2-нд Саудын Арабад 346 мөргөлч бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан;
- 2006 оны 10 сарын 3-нд БНХАУ-д цэнгэлдэхэд болсон концертын үеэр 11 хүн бусдын хөлд гишгэгдэж амь насаа алдсан;
- 2006 оны 2 сарны 6-нд Филиппин Улсын нийслэл Манила хотын спортын цэнгэлдэх хүрээлэнгийн гадаа 93 хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдаж, 300 орчим хүн гэмтэж бэртсэн;
- 2007 оны 2 сарын 2-нд Камбожи улсад хөл бөмбөгийн хөгжөөн дэмжигчдийн гаргасан үймээний үеэр цагдаагийн 5 алба хаагч амь насаа алдсан;

Монгол Улсад:

- 2002 онд Нарантуул захын дээвэр нурснаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдал;
- Хадгаламж зээлийн хоршооны хэргийн шүүх хуралдаануудын үеэр болсон эмх замбараагүй байдал;
- Бөмбөгөр худалдааны төвийн гал түймэр;

Алтжингийн хэргийг шүүх хуралдааны дараа болсон эмх замбараагүй байдал;

- 2008 оны 7 сарын 1-нд сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн жагсаал олон нийтийг хамарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гарч 4 хүний амь нас хохирч олон хүн гэмтэн их хэмжээний хохирол улсад учирсан;
- Нарантуул худалдааны төвд гарсан гал түймэр гэх мэт олон үйл явдлыг нэрлэж болно.

Дээрх үйл явдлуудаас харахад хөгжсөн гадаадын улс оронд ийм хор хохирол бий болж олон зуун хүн бэртэж гэмтэж амь насаа алдаж асар их хохирол амсаж

[1] Даваадорж. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэхүй. УБ. 2009. 5 дах тал.

байгаа нөхцөл байдал нь хөгжингүй буурай манай орны хувьд нөхцөл байдлыг эртнээс үнэлж дүгнэж урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэс дараатай зохион байгууллалттай авч хэрэгжүүлэхгүй бол хичнээн нөхцөл байдал тайван байдаг ч сүүлийн жилүүдэд гарч байгаа улс төр эдийн засаг байгаль цаг уурын тогтворгүй байдлаас үүдэн төсөөлж байршгүй хор хохирол бий болзошгүй байна.

Онцгой нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох асуудлыг улс орон бүхэн өөрийн эдийн засаг, нийгэм, байгаль, цаг уурын өнөөгийн байдал, цаашдын хандлага, үндэсний аюулгүй байдал, хөгжлийн бодлого, стратеги бодлоготойгоо уялдуулан авч үзэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Ардчилсан гэх өнөөгийн нийгэмд шинжлэх ухаан , техник технологи эрчимтэй хөгжсөн нь хүн төрлөхтний амьдрах орчны ая тухтай амьдрах нөхцлийг эрс өөрчилж байгаа боловч стандарт бус үйлдвэрлэл, хотжилт, хүн амын өсөлтийн төлөвлөгөөт бус нягтрашил нь байгалийн болон хүний гаралтай[1] хүний хүчин зүйлээс үл хамаарах байгалийн гамшиг хүний үйл ажиллагаанаас үүсэлтэй гамшгийг үүсэх нөхцлийг бий болгож байна[2].

Гамшиг гэдэг нь эрдэмтэд судлаачдын тодорхойлсноор “Нэрвэгдсэн орон нутагт өөрсдийн хүч нөөцийг ашиглан тэмцэх боломжоос давсан , хүн ам, эд хөрөнгө, эсвэл хүрээлэн буй орчинд их хэмжээний хохирол учруулах, нийгмийн үйл ажилллагааг ноцтой алдалдагдуулахыг гамшиг гэнэ” гэж тодорхойлсон байдаг[3]. Харин Гамшгийн тухай хуулийн 4.1.2-т “Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажилллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, хүрээлэн байгаа орчинд улс орон нутгийн дотоод нөөц бололцооноос давсан хохирол учрахыг” хэмээн тодорхойлсон байдаг[4].

Онцгой нөхцөл байдлаас үүссэн гамшиг аюул хор нөлөөллийн хурдац тархац нь тухайн бүс нутгийн хүн амын нягтрашил, үл хөдөлх хөрөнгийн байршил, дэд бүтэц болон эдийн засгийн бүс нутгийн чадавхиас хамааран эмх замбраагүй байдлыг харилцан адилгүйгээр бий болгодог. Гамшгийн учруулсан хор хохирлын хэр хэмжээ нь хир их байгаагаас хамаарч улс оронд онц байдал зарлах, эсхийг шийдвэрлэдэг ба тэмцэх үйл ажиллагааг олон салбар хуулиудаар зохицуулдаг. Монгол улсын үндсэн хуульд заасны дагуу онц байдал зарлаж болно. Үүнд:

Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул /газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үер, түймэр, цацраг идэвхт бодисын тархалт, хордуулалт хүн малын гоц халдварт өвчин зэрэг/ тохиолдсон.

Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогноход заналхийлсан аливаа байгуулллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажилллагааны улмаас үүссэн нийгмийн эмх замбараагүй

[1] Б.Баянмөнх. Онцгой нөхцөл байдлын үед цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үйл ажиллагаа. УБ. 2013. 9 дэх тал.
[2] П.Баяртогтох, Б.Баяржаргал. Гамшиг ослоос хамгаалах гарын авлага. УБ. 2006. 5дах тал.
[3] О.Үржин, Ш.Болдбаатар. Гамшгийн менежмент: гутгаар дэвтэр. УБ. 2004. 8 дах тал.
[4] Төрийн мэдээлэл. эмхэтгэл. 1992 №1.

байдлыг төрийн байгуулллага эрх хэмжээнийхээ хүрээнд ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон[1] зэрэг нөхцлүүд орно. Онц байдал нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн 25-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ’’Онцгой нөхцөл байдал бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн амын нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу хүний эрх эрх чөлөөг, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуй нэгж байгууллагын үйл ажилллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэм юм[2]. Эрдэмтэн судлаачид гамшгийг байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөлөлийн гаралтай гэж ангилж үздэг.

**Байгалийн гамшнгт:**

цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл

геологийн гаралтай аюулт үзэгдэл

биологийн гаралтай аюулт үзэгдэл

**Хүннй үйл ажиллагаанаас үүсэлтэй гамшигт:**

- дайн эсвэл зэвсэгт мөргөлдөөн
- тэсэрч дэлбэрэх химийн бодис
- үйлдвэрлэлийн осол, аваар
- гал түймэр
- машин техникийн холбогдолтой осол аваар
- цөмийн технологитой холбоотой осол аваар гэх мэт авч үздэг.

Хүний буруутай үйл ажиллагаанаас үүссэн гамшгийг илрэн гарах гадаад хэлбэрээр мөн технологийн гаралтай осол, нийгмийн гаралтай осол гэж ангилдаг.

Дээрхи онцгой нөхцөл байдал бий болж учруулсан хор уршиг нь гамшгийн хэмжээнд хүрэх буюу хүрч болзошгүй нөхцөлд /нийтийн эмх замбараагүй байдал, байгалийн болон хүний гаралтай гамшиг, хүн, малын гоц халдварт өвчин, үйлдвэрлэлийн томоохон осол/ цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд бэлэн байх учирч болзошгүй гамшиг бүрийн онцлогт тохирсон үйл ажилллагааг мэргэжлийн өндөр түвшинд удирдан зохион байгуулах цаашид боловсронгуй болгохын тулд бэлтгэл сургуулилт дадлага туршлагыг бий болгох явдал улам бүр чухал асуудал болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлэг 19-р зүйлд “хүний эрх эрх чөлөөг хангахуйц, эдийн засаг, нийгэм хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна” гэсэн заалт нь хууль сахиулах байгууллагуудын үндсэн зарчим ба үүнийг биелүүлхэд эрх зүйн орчин хамгаас чухал зүйл юм.

Монгол Улсын хөгжлийн чиг хандлагад сүүлийн жилүүдэд ихээхэн нөлөөлөх хүчин зүйлүүд нь байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал ба энэ үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын эрх зүйн зохицуулалт нь хангалтгүй учир дутагдалтай байгаа нь зарим зүйлүүдээс харагдаж байгаа болно.

[1] Онц байдлын тухай Монгол Улсын хууль.
[2] Онц байдлын тухай Монгол Улсын хууль.

Жишээ нь: 2008.07.01 нд сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй хууль бус жагсаал цуглаан болж нөхцөл байдал хүндэрч ердийн арга хэлбрээр зохицуулах нөхцөлгүй болж нийтийг хамарсан эмх замбараагүй байдал болон хувирч үүний улмаас 5 хүний амь нас хохирч олон хүн эрүүл мэндээрээ хохирон улсад их хэмжээний хохирол учирсан. Энэ нөхцөл байдлын хариуцлагыг цагдаагийн байгууллагын удирдлагадуудад хүлээлгэсэн ба үүнийг зарим ард түмэн шударга бус хариуцлага гэж үздэг.

Иймд онцгой нөхцөл байдал /нийтийн эмх замбараагүй байдал, байгалийн гамшиг, хүн, малын гоц халдварт өвчин, үйлдвэрлэлийн томоохон осол/ бий болсон үед цагдаагийн байгууллага өөрт хариуцуулсан үүргийг хэрхэн гүйцэтгэх ямар субьектын удирдлага доор үүрэг гүйцэтгэх зэргийг хуулинд нарийвчлан оруулж өгох нэн шаардлагатай юм. Ингэснээр гамшгийн үед ажиллах байгууллагуудын эрх зүйн баталгаа хангагдана.

Онцгой нөхцөл байдал бий болоход Монгол Улсын Засгийн газар, түүний харъяа байгууллагууд хамгийн хор хохирол багатай даван гарах ажлыг удирдан зохион байгуулах нь хамгийн гол зорилт юм.

Онцгой нөхцөл байдал бий болсон үед цагдаагийн байгууллага өөрийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа хүчний байгууллагуудтай хамтрах, хамтран ажиллаж болох бусад албад, ажиллах арга хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан цагдаагийн байгууллагын тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн эрх зүйн актаар зохицуулах шаардлага тулгарч байна.

**Санал**

1. Онцгой нөхцөл байдлын үед удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж буй субьектуудын үүрэг гүйцэтгэх эрх зүйн баталгааг хангах шаардлагатай. Жишээ нь: *2008.07.01-ны өдөр гарсан эмх замбараагүй байдлын үеэр үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагч нарт хариуцлага хүлээлгэсэн.*

2. Үүрэг гүйцэтгэх албан тушаалтан тэдгээрийн үүргийг тодорхой болгон хариуцлагыг нарийвчлан хуулинд тусган оруулах ба онцгой нөхцөл байдлын үед удирдан зохион байгуулах шуурхай штабын дарга, гишүүдэд хийж гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг хуулинд нарийвчлан тусгах шаардлагатай гэж дүгнэж байна.

Жишээ нь: *УАБЗ-н гишүүн шуурхай удирдлагын штабын дарга ба хийж гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох.*

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*цагдаагийн хошууч Б.Энхчулуун*

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Аливаа байгууллагын зорилго, үйл ажиллагаа хүмүүсээр дамжин хэрэгждэг. Тиймээс бид хүний нөөцийг хэрхэн зөв оновчтой удирдан зохион байгуулах, ямар шаардлага шалгуурыг хангасан алба хаагчдаар эгнээгээ бэхжүүлэх, мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуультайгаа хэрхэн хамтран ажиллах, сонгосон алба хаагчдийн ухамсар, ёс зүйг шинэчлэлийн үетэй хэрхэн нийцүүлж өөрчлөх, хөгжүүлэх, сургаж